

ЭД ХАРИУЦАГЧИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээг нэг талаас Хан-Уул эрүүл мэндийн төвийн захиргааг төлөөлж Э.Бодьцэцэг /цаашид ажил олгогч гэх/, нөгөө талаас иргэн овогтой нар Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 132, 133, 135 дугаар зүйлийг үндэслэн доор дурдсан нөхцлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.2. Энэхүү гэрээг Монгол улсын мөрдөгдөж буй үл хөдлөх хөрөнгө, барилга байгууламж, ажлын байр, тоног төхөөрөмжийг нэр төрөл, чанар байдал, эдлэгдсэн жил зэргийг харгалзан үзэж хүлээлгэн өгч, хүлээн авсан актыг харгалзан хохирол учруулсан тохиолдолд эд хөрөнгийн бүрэн болон хязгаарлагдмал хариуцлага хүлээлгэх, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцааны доголдол гарсан тохиолдолд ёс зүйн хороогоор хянан шийдвэрлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

ХОЁР. АЖИЛ ОЛГОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Эд хариуцагчийг ажиллах нөхцөл, орон байр, төхөөрөмж, хэмжих, шалгах хэрэгсэл, хөтлөгдөх бүртгэл тайлангийн маягт, заавраар бүрэн хангана.
- 2.2. Эд хөрөнгийн хариуцагчийг ажлаас халагдах, өөрчлөгдөхөд байгууллагын захиргаанаас томилогдсон комисс эд хариуцагчийн хариуцлагад байгаа зүйлийн тооллого тооцоог бүрэн хийж дүгнэлт гаргана.
- 2.3. Эд хариуцагч гэрээг зөрчиж хариуцсан эд хөрөнгийг гэмтээх, чанарыг нь алдагдуулах, тооцоог будилаантуулах, идэж ашиглах, үрэгдүүлсэн явдал илэрвэл хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 2.4. Эд хөрөнгийг санаатайгаар идэж ашигласан, үрэгдүүлж шамшигдуулсан үйлдсэн гэмт хэргийн шинж чанараас шалтгаалан ажилаас чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.
- 2.5. Эмч эмнэлэгийн ажилчдын талаар иргэдээс гарсан гомдолыг шийдвэрлэнэ.

ГУРАВ. ЭД ХАРИУЦАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 3.1. Эд хариуцагч нь Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль болон байгууллагын дотоод журамд захирагдаж, өөрийн гүйцэтгэх ажил үүрэг, сар, улирал, жилийн төлөвлөгөөт ажлыг цаг хугацаанд нь биелүүлж ажиллана.
- 3.2. Өөрийн хариуцаж байгаа мөнгөн хөрөнгө болон бараа материал, түүхий эд, тоног төхөөрөмж, эд хогшил, үнэт цаас, эм тариа, ороох боох материалыг хүлээн авахдаа түүний тоо, үнэ, чанар, бүрэн бүтэн эсэх болон зохих баримт бичгүүдтэй тохирч байгаа эсэхийг шалгаж дутуу зүйлийг нөхөж авна.
- 3.3. Хариуцаж байгаа эд зүйл нь орон байр, хадгалалтын нөхцлөөс болж чанар алдагдах үрэгдэхэд хүрвэл тухай бүр нь байгууллагын удирдлагад мэдэгдэж арга хэмжээ авахуулж байна.
- 3.4. Хариуцаж байгаа эд хөрөнгийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг нягтлан бодогчид тухай бүрт гарган өгч, эд зүйлийн үлдэгдлийн тооллого хийх, тооцоо бодоход өөрийн биеэр оролцож байх ба тооллого хийгдэж байгаа зүйл нэг бүрийг биечлэн үзүүлж тооцуулна.
- 3.5. Эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, зарцуулалтын талаар зайлшгүй шаардагдах орон байр, тоног төхөөрөмж, ажлын багаж хэрэгсэл, цоож лац бүтгэлийн маягт заавар зэргээр хангаж өгөхийг шаардах эрхтэй.

ДӨРӨВ. БУСАД ЗҮЙЛ

- 4.1. Гэрээтэй холбогдуулан гарсан асуудлыг хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэх ба тохиролцоогүй асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 4.2. Энэхүү гэрээг 20.... оны сарын ны өдөр байгуулав.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн
даргаЭ.Бодьцэцэг

Ажилтан

.....